

ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 дүгээр сарын 18

№02

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр ШУТТНС-ийн хурлын танхимд (Е-604) 11:00 цагаас 82,6 хувийн ирцтэй явагдав.

Хуралд: дарга Н.Эрдэнэхүү, нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа, гишүүн Д.Оюунцэцэг, М.Оюунчимэг, Б.Оюунтунгалаг, Г.Өлзийсайхан, А.Болормаа, Я.Батцэцэг, Ш.Цоож, П.Ууганбаяр, Г.Батцэцэг, Г.Мөнхсайхан, Ч.Улам-Оргил, Д.Ариунболор, Д.Цэрэндолгор, Б.Аюурзана/цахим/, Б.Мөнхцэнгэл, Ц.Энхтуул, Г.Ариунтөгс нар оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “071501. Механик инженерчлэл” бакалаврын хөтөлбөрөөр (2.5+2) Япон улсын Нагаока технологийн их сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (МехТС)
 - МехТС-ийн Техник, механикийн тэнхимийн дэд профессор П.Цэрэнчимэд
2. “073204. Барилгын инженерчлэл” бакалаврын хөтөлбөрөөр (2.5+2) Япон улсын Нагаока технологийн их сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (БАС)
 - БАС-ийн Барилгын инженерийн салбарын эрхлэгч М.Оюунчимэг
3. “104102. Тээврийн үйлчилгээ” магистрын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (МехТС)
 - МехТС-ийн Тээврийн салбарын эрхлэгч И.Базаррагчаа
4. “073207. Усны барилга, байгууламж” магистрын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (БАС)
 - БАС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Аюурзана
5. “041101. Нягтлан бодох бүртгэл” магистрын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (ЭЦДС)
 - ЭЦДС-ийн сургалтын албаны дарга Д.Болор-Эрдэнэ
6. Коосэн технологийн коллежийн дэд бакалаврын хөтөлбөрийг шинэчлэх
 - Коосэн технологийн коллежийн Инженер, технологийн тэнхимийн эрхлэгч С.Дэлгэрмаа
7. ШУТИС-ийн хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага
 - Ахисан түвшний хөтөлбөрийн алба, Сургалтын бодлого, хөтөлбөрийн алба
8. Бусад (МХТС, ДаТС-ийн бакалаврын хамтарсан хөтөлбөрт оруулах өөрчлөлтийн санал)

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. МехТС-ийн “071501. Механик инженерчлэл” бакалаврын хөтөлбөрөөр (2.5+2) Япон улсын Нагаока технологийн их сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай асуудлыг дэмжлээ.
2. БАС-ийн “073204. Барилгын инженерчлэл” бакалаврын хөтөлбөрөөр (2.5+2) Япон улсын Нагаока технологийн их сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай элсэлтийн чиглэлд оруулж зарлах, БАС-ийн хариуцсан салбар хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн саналыг тусган сайжруулалт хийгээд 5 сард дахин хэлэлцүүлэхийг дэмжлээ.
3. МехТС-д шинээр нээх “104102. Тээврийн үйлчилгээ” магистрын сургалтын хөтөлбөрийг БШУЯ-аас шинээр баталсан нийтлэг шаардлагад нийцүүлэн, ХЕХ хорооны гишүүдийн санал, зөвлөмжийн дагуу сайжруулан хэрэгжүүлэхийг дэмжлээ.
4. БАС-ийн “073207. Усны барилга, байгууламж” магистрын сургалтын хөтөлбөр
 - ССWater төслийн хүрээнд боловсруулсан гурван хичээлийг Усны барилга байгууламжийн магистрын хөтөлбөрт оруулан хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсныг дэмжлээ.
 - “073207. Усны барилга, байгууламж” магистрын сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэлийн хүсэлт гаргахыг дэмжлээ.
5. ЭЦДС-д хэрэгжүүлэх “041101. Нягтлан бодох бүртгэл” магистрын сургалтын хөтөлбөрийг ХЕХ-ны гишүүдийн санал зөвлөмжийн тусган сайжруулж батлуулахыг дэмжлээ.
6. Коосэн технологийн коллежийн Цахилгаан электроник, Механик инженерчлэл, Барилгын инженерчлэл, Мэдээллийн технологи хөтөлбөрийн хувь, харьцаа кредитийг өөрчлөх дээр ХЕХ-ны гишүүдийн санал, зөвлөмжийг тусган ажиллахыг дэмжлээ. Хөтөлбөрийн боловсруулалт дээр хөтөлбөрийн хорооны үнэлгээ хийж, сайжруулалтад дэмжлэг үзүүлж ажиллахыг дараах гишүүдийг чиглэл бүрээр томилов.
 - Цахилгаан электроник - Ч.Улам-Оргил
 - Механик инженерчлэл - Ш.Цоож
 - Барилгын инженерчлэл - М.Оюунчимэг
 - Мэдээллийн технологи - П.Ууганбаяр
 - Ерөнхий эрдмийн хичээл дээр - Г.Мөнхсайхан, А.Болормаа багш нар ажиллаж зөвлөмж гаргана.
7. ДаТС-д МХТС-тай хамтран хэрэгжүүлж буй Кибер аюулгүй байдал, Мэдээллийн систем (1+3) бакалаврын хөтөлбөрийг (2+2) хэлбэр болгон хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн санал, зөвлөмжийг тусган төлөвлөлт хийж ажиллахыг дэмжлээ.
8. “ШУТИС-ийн хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг шинэчлэх” асуудлыг хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн саналаар БШУЯ-аас гаргасан 2024 оны “Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-д нийцүүлэн ШУТИС-ийн хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага гарган ажиллахаар шийдвэрлэв. Танилцуулгын хүрээнд дараах зарим үндсэн бүтэц, агуулгыг баримтлахыг дэмжлээ.

Бакалаврын хөтөлбөрт:

- Бакалаврын цөм хөтөлбөрийн шаардлага болон хөтөлбөрийн загвар файлд байгаа холбогдох мэдээлэл, зүйл заалтыг оруулан нэгдсэн нэг шаардлага батлах

- Цөм хөтөлбөрийн ерөнхий суурь хичээлийн агуулгын хүрээг тодорхойлсон ангилалыг БШУЯ-ны нийтлэг шаардлагын байгалийн ухаан, хүмүүлэгийн ухаан, нийгмийн ухаан, амьдрах ухаан, салбар чиглэлийн ерөнхий суурь ангилалд нийцүүлэх.
- Бакалаврын сургалтын хөтөлбөрийн багц цагийн ерөнхий хуваарилалтыг 30:30:40 харьцааг баримтлан боловсруулах.
- Суралцахуйн үр дүнгээр нь хуульд заасан агуулгыг судлуулахаар нийтлэг шаардлагад тусгасан тул энэ зарчимд үндэслэн ерөнхий суурийн зарим хичээлийг сургуулиас санал болгох заавал судлах хичээлд буюу сургалтын төлөвлөгөөний D ангилалд оруулах дээр СБХА-аас санал боловсруулж, танилцуулах.
- Хичээлийн хөтөлбөрийн загварын үнэлгээний аргачлал хэсгийн өөрчлөлтөд хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүд санал ирүүлэх

Ахисан түвшний хөтөлбөрт:

- Мэргэжлийн магистрын дадлага 5 байх
- Докторын хөтөлбөрийн бүтэц дээр мэргэжлийн нэгдсэн шалгалт 2, докторын диссертацийн ажил 22 кредит байх